



**НИЙСЛЭЛИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

Байгууллагын тамга, тэмдэг хэвлэмэл
хуудас хийлгэх, хэрэглэх, хадгалах
ажлыг хариуцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Журам шинэчлэн батлах тухай” 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”, 2025 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 126 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын тамга, тэмдэг түших, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх, хадгалах ажлыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Архив, бичиг хэргийн эрхлэгч Б.Ганширнэнд хариуцуулсугай.

2. Байгууллагын тамга, тэмдэг, хэвлэмэл хуудсыг зөвшөөрөгдсөн газраар хийлгэн ашиглалт, хамгаалалт, зарцуулалтыг холбогдох журмын дагуу хэрэгжүүлж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн Архив, бичиг хэргийн эрхлэгч Б.Ганширнэнд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга М.Цогзолмаад үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан газрын даргын “Байгууллагын тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх ажлыг хариуцуулах тухай” 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/77 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.




ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.САРАНЦЭЦЭГ

172501143

БАЙГУУЛЛАГАД АШИГЛАГДАЖ БАЙГАА ТАМГА,
ТЭМДЭГ, БАТАЛГААНЫ ТЭМДГИЙН НЭРС

№	Тамга, тэмдэг түших албан тушаалтан	Тэмдгийн нэр	Тэмдэгийн хэв
1	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Даргын тамга	
2	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Байгууллагын тэмдэг	
3	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Боловсруулсан хянасан	Боловсруулсан хянасан: хувь:
4	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Хуулбар үнэн	
5	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Архивын нүүр бичилт	
6	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Баримт хүлээн авсан тэмдэг	

7	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Архивын нүүр бичилт	
---	---------------------------------	------------------------	--

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР
ТТБ д. 3279

СХ №

Д №

ХН №

بصر و

172501080